

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨНД  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: ГАГ-2019/01/-ГА**

БАЯНХОНГОР АЙМАГТ ЭРХ ШИЛЖИЖ ИРСЭН  
УЛСЫН ТӨСВИЙН 2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨНД  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баянхонгор хот 2019 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**  
Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер **Д.Цэцэгмаа**  
Утас: 70442424 цахим хуудас: [tsetsegmaadam@audit.gov.mn](mailto:tsetsegmaadam@audit.gov.mn)  
**Аудитор Б.Азбаяр**  
Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)  
**Аудитор Б.Цэрэнчимэд**  
Утас: 88302569 цахим хуудас: [tserenchimedb@audit.gov.mn](mailto:tserenchimedb@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу

---

## 1 ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Ерөнхий аудиторын Орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/103 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

### Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-нд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон уу

Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд Баянхонгор аймагт санхүүжүүлсэн 24 төсөл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын үйл ажиллагааг хамруулав.

### Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймагт 2018 онд Төсвийн тухай хуулиар 16968.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8781.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 23 төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийхээр төсөв батлагдсан байна.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аймгийн ЗДТГ, аймгийн ГХБХБГ-ын албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Барилгын тухай хууль

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль
  - Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
  - Монгол улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
    - Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
    - Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”.
    - Олон улсын төсвийн түншлэлийн үнэлгээ
    - Олон улсын ил тод байдлын хүрээлэнгийн үнэлгээ
    - Монгол улсын зээлжих зэрэглэл
    - Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын судалгаа
    - Батлагдсан зураг, төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт
    - Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдан, аудитын менежер Д.Цэцэгмаа аудитын үе шат бүрд хяналт тавьж, аудитор Б.Цэрэнчимэд, аудитор Б.Азбаяр нар 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, ҮАГ, аймгийн ТЭЗ болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн “Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийлээ.

### **А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөх зохистой арга хэмжээг авч байна уу?**

*Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн санал, Баянхонгор аймгийг хөгжүүлэх 2016-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон 2018 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.*

*А.1.1. Баянхонгор аймагт 2018 онд эрх шилжиж хэрэгжсэн зарим төсөл, арга хэмжээ нь Баянхонгор аймгийг хөгжүүлэх 2016-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл болон 2018 онд нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байна.*

2018 онд эрх шилжсэн 23 төсөл арга хэмжээний жагсаалтыг Баянхонгор аймгийг хөгжүүлэх 2016-2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 35, 45, 47, 68, 71 дэх заалтуудтай, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн “Б”-ийн 10, 13, 14, В-ын 34, “Г”-ийн 45, 52 дахь заалтуудад заагдсан арга хэмжээтэй уялдаж байна.

*А.1.2. Баянхонгор аймагт эрх шилжиж батлагдсан төсөл, арга хэмжээнүүд нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний харьяа байгууллагуудын саналыг үндэслэн батлагдсан байна.*

УТХО-д батлагдаж, орон нутагт эрх шилжиж ирсэн 23 төсөл, арга хэмжээнээс Баянхонгор суманд баригдах 280 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баянхонгор суманд баригдах Ахуйн үйлчилгээний барилга нь УИХ-ын гишүүний санаачилгаар, ГХБХБГазрын барилгын засвар, Зооноз өвчин судлалын төвийн барилгын засвар нь тухайн байгууллагын саналаар, үлдсэн 19 төсөл арга хэмжээ нь аймгийн ТЕЗ-аас явуулсан саналын дагуу улсын төсөвт батлагдсан байна.

**Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Аймгаас УТХО-аар хийгдэх төсөл, арга хэмжээнд оруулахаар хүргүүлсэн санал
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Өлзийт сум/	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.3.4
2	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.3.5
3	Архивын хэлтсийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.3.4
4	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын засвар Баянхонгор	Баянхонгор аймгийн ГХБХБГ-ын саналаар
5	Сургуулийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум, Баян-Ойт сургууль/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.9
6	Дотуур байрын барилга /Баянхонгор, Жинст сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
7	Цэцэрлэгийн барилгын дуусгал /Баянхонгор, Баянхонгор сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
8	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	УИХ-ын гишүүны саналаар
9	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, Баянговь сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.5
10	Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Баянхонгор, Баянхонгор, Шинэжинст сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
11		БСШУЯ-д явуулсан саналын 1.4.8
12	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Богд сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
13	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Жинст сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
14	Ахуйн үйлчилгээний төвийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	УИХ-ын гишүүны саналаар
15	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Жаргалант сум/	ЭМЯ-д явуулсан саналын 1.3.1
16	Сургуулийн дотуур байрны халаалт, цахилгааны засвар /Баянхонгор, Шинэжинст сум/	Тухайн байгууллагын саналаар
17	Сургуулийн барилгын засвар /Баянхонгор, Богд сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.4.6
18	Цэцэрлэгийн барилгын дээвэр засвар /Баянхонгор, Галуут сум/	БСШУЯ-д явуулсан саналын 1.3.4
19	Сургуулийн гадна шугам сүлжээний засвар /Баянхонгор, Баянөндөр сум/	Тухайн байгууллагын саналаар
20	ЗООНОЗ-ын барилгын сантехникийн их засвар	Тухайн байгууллагын саналаар
21	Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГазарт автомашин	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.5.2
22	Баянхонгор аймгийн ЗДТГазарт автомашин	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.5.1
23	Жинст сумын ЗДТГазрын автомашин	ЗГХЭГ-т явуулсан саналын 1.5.2

**А.2. Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан уу?**

*Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийн магадлалын дүгнэлт нь төсөв батлагдах үед хийгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.*

*А.2.1. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн 23 төсөл арга хэмжээний хувьд хэрэгжих хугацаа болон байршлыг тодорхой заажээ.*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхойгүй төсөл, арга хэмжээг батлаагүй байна.

*А.2.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийн магадлалын дүгнэлт нь төсөв батлагдах үед хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.*

Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний төсвийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нэр нь батлагдсаны дараа буюу 2018 онд Барилгын хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлт гаргажээ.

*Тухайлбал: Өлзийт, Эрдэнэцогт сумдын ЗДТГ-ын барилга 2018.03.02-нд, Архивын хэлтсийн барилга 2018.06.21-нд, Баян-Ойт сургуулийн барилга 2018.05.03-нд, Жинст сумын дотуур байрны барилга 2018.03.17-нд, Баянговь сумын цэцэрлэгийн барилга 2018.06.28-нд, Богд, Жинст сумын 240 суудалтай соёлын төвийн барилга 2018.12.18-нд, Шинэжинст сумын сургуулийн засвар нь 2018.02.13-нд тус тус магадлал хийлгэж хянагдсан бөгөөд бусад засварын ажлууд нь магадлал хийлгээгүй байна.*

Дээрх магадлал хийгдсэн огноог харахад төсөв батлагдах үед зураг төсөл хянагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29-р зүйлийн 29.4-т заасан “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Харин Баянхонгор аймгийн төвд баригдаж буй 280 ортой цэцэрлэгийн барилга болон Ахуйн үйлчилгээний төвийн барилгууд нь 2014 онд магадлал хийлгэж, зураг төслийг хянуулжээ.

*А.2.3. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн шинээр баригдаж байгаа барилга байгууламжийн хувьд техникийн нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна.*

Эрх шилжүүлсэн 23 төсөл арга хэмжээний 11 нь шинээр баригдаж байгаа барилга байгаа ба барилгын техникийн баримт бичгээс газрын захирамж болон техникийн нөхцөлийг авч шалгаж үзэв.

Аудитаар Баянхонгор суманд баригдаж буй 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Богд, Жинст сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын газрын захирамж нь 2018 онд гарсан, Өлзийт сумын ЗДТГ-ын барилгын дулаан болон холбооны, Эрдэнэцогт

сумын ЗДТГ-ын барилгын цахилгааны болон холбооны, Баянхонгор сумын төвд баригдаж буй 280 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Баянговь сумын цэцэрлэгийн барилга, Богд, Жинст сумдын 240 суудалтай соёлын төвийн барилгуудын холбогдох бүх техникийн нөхцөлийг 2018 онд авсан байна.

*А.2.4. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээнээс 1 барилгын төсөвт өөрчлөлт орсныг дахин магадлал хийлгэсэн байна.*

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд баригдаж буй ЗДТГ-ын барилга нь 2018 оны төсөв батлагдахад анх 850.0 сая төгрөгөөр төсөвт суусан бөгөөд 2 удаа тендер зарлаад гүйцэтгэгч материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулахаар тохиролцсон бөгөөд тус барилгыг зорин давхар болон цэвэр ус, ариутгах татуургын холболтын ажлыг нэмж хийхээр төлөвлөж төсөвт өөрчлөлт оруулж 2019 улсын төсөвт 1270.1 мянган төгрөгөөр төлөвлөн баталсан байна. Тухайн нэмэлт ажлын төсөвт 2019.01.07-ны өдөр магадлал хийлгэсэн байна.

*А.2.5. Шинэжинст сумын барилгын засварын ажлын хэрэгцээ шаардлагыг буруу тодорхойлсноор төсвийн зөрүүтэй байдал үүсжээ.*

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй засварын болон тоног төхөөрөмжийг анхан шатны нэгжийн хүсэлтийг үндэслэн шийдвэрлэж байгаа боловч Шинэжинст сумын дотуур байрны гадна халаалтын засвар нэртэй төсөвт тусгагдсан ажлын төсвийг хийлгэхдээ дотор санхтехникийн засварын ажлаар төсөв хийгдсэн байна. Аудитаар газар дээр нь очиж шалгахад ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу дотор цахилгааны ил монтажийн ажил хийгдсэн ба энэ талаар ашиглагч байгууллагын удирдлагаас тодруулахад:

*Анх төсөв хийлгэх захиалгаа өгөхдөө дотор сантехникийн засвар, дотор цахилгааны монтажийн засварын ажлыг хоёуланг нь хийлгэхээр захиалгаа өгсөн боловч, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс төсөвт багтаан зөвхөн дотор сантехникийн төсөв хийлгэж тендер зарласан. Тус дотуур байрны цахилгааны монтаж масс үүссэн бөгөөд ашиглах боломжгүй болоод байсан учраас гүйцэтгэгч нь манай хүсэлтийн дагуу цахилгааны монтажийн ажлыг хийсэн” гэсэн тайлбар өгөв.*

Дээрх нөхцөл байдлаас харахад хэрэгцээ шаардлагатай асуудлаа шийдвэрлэхдээ нэн тэргүүний асуудлыг шийдээгүй, хэрэгцээ шаардлагаа оновчтой тодорхойлоогүйгээс төсөвт заагдсан ажил өөрчлөгдсөн байна.

*А.2.6. Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн 23 төсөл арга хэмжээний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.*

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн 23 төсөл арга хэмжээний жагсаалтад хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

**Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?**

*ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчин 2017 онд гүйцэтгүүлж ашиглалтад орсон хөрөнгө оруулалтын ажилд тендер зарласан байна.*

*Б.1.1 Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.*

Баянхонгор аймагт 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжүүлсэн 23 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2017 оны 12 дугаар сард 1, 2018 оны 1 дүгээр сард 12, 3 дугаар сард 2, 4 дүгээр сард 6-н төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирсэн байна. Харин 2019 оны 11 дүгээр сард Жинст сумын ЗДТГ-ын автомашиныг худалдан авах эрх шилжиж ирсэн байна.

Эндээс харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн хугацаа нь барилгын ажил хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна.

*Б.1.2 Аймгийн Засаг дарга үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан боловч 2017 онд урьдчилан гүйцэтгүүлж, ашиглалтад орсон хөрөнгө оруулалтын ажилд тендер зохион байгуулж ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрсөн байна.*

Улсын төсвөөр хэрэгжих 12 төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн шийдвэр 2018 оны 1 дүгээр сард гарсан байхад тендер шалгаруулалтын үнэлгээний хороог 2018 оны 3 дугаар сарын 7-оос эхэлж байгуулсан нь эрх шилжсэнээс хойш бараг 2 сар буюу 60 орчим хоногийн хугацаа алдсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь үнэлгээний хороог хууль, эрх зүйд нийцүүлэн гаргажээ.

2018 онд аймгийн Орон нутгийн өмчийн газар 21 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж Зооноз өвчин судлалын төвийн засварын ажлыг аймгийн Эрүүл мэндийн газарт эрх нь шилжин, Богд сумын дээврийн засварын ажлыг Улаанбаатар хотод Дэлхийн зөн олон улсын байгууллага зохион байгуулсан байна.

Аудитаар эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний тендерийг хуулийн дагуу зохион байгуулсан боловч 758.4 сая төгрөгийн Цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажлыг 2017 онд “Хаш гоёо” ХХК-аар урьдчилан сонгон шалгаруулж гүйцэтгүүлсэн байхад үлдэгдэл санхүүжилтийн ажилд дахин тендер зарласан нь ТБОНӨХБАҮХАТХуулийг зөрчсөн байна.

*Б.1.3 Тендерийн баримт бичгийг хууль, журмын дагуу боловсруулсан байна.*

Төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамжаар байгуулагдсан үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг боловсруулах асуудлыг ихэнх тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагчийн захирамж гаргасан өдөр, зарим үед 2-3 хоногийн дараа хуралдаж хууль журмын дагуу шийдвэрлэж, боловсруулсан бөгөөд тендер шалгаруулалтын холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар болон “Монголын үнэн” сонин хэвлэлээр олон нийтэд нээлттэй мэдээлж, зарласан байна.

*Б.1.4 Гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, хугацаанд нь тайлагнаж ажилласан байна.*

Тендер шалгаруулалтын холбоотой мэдээлэл, тендерт оролцоход шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж, оролцох байгууллагын материалыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар авч, оролцогчид болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товросон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

*Б.1.5 Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны тайланг үнэн, зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.*

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тайланг Сангийн сайдын 2017 оны 363 тоот тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, журам”-ын дагуу батлагдсан маягтаар болон бичмэл тайлангаар хагас бүтэн жилээр гарган сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

### **Б.2 Гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлсэн үү?**

*Баянхонгор аймагт 2018 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэгчид гэрээний үүргээ биелүүлж ажилласан байна.*

*Б.2.1 Эрх шилжиж хэрэгжсэн 15 төсөл арга хэмжээ ашиглалтад орсон ба дээрх ажлууд нь ашиглалтын шаардлага бүрэн хангаж байна.*

Баянхонгор аймагт эрх шилжин ирсэн 23 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 15 ажил нь 2018 онд ашиглалтад орсон бөгөөд үүний 12 төсөл, арга хэмжээ нь барилгын болон засварын ажил байна. Аудитаар тухайн ажлууд дээр газар дээр очиж шалгасан бөгөөд ашиглалтын явцад зөрчилтэй асуудал гараагүй.

Харин Баян-Ойт сургуулийн барилгын гүйцэтгэгч “Хаш гоёо” ХХК нь тус барилгын ажлыг 1973,5 мянган төгрөгөөр гүйцэтгэх, ингэхдээ 2018 онд 500,0 сая төгрөг, үлдэх 1473,5 сая төгрөгийн санхүүжилтийг 2019 онд авч, ажлаа 2018 оны 12 дугаар сарын 19-нд ашиглалтад бүрэн оруулах гэрээ байгуулсан боловч сургуулийн спорт заалны барилга болон гадна тохижилтын ажлыг хийгээгүй байна. Энэхүү ажил нь 2019 онд хийгдэхээр гэрээг сунгасан байна.

*Б.2.2. Мэргэжлийн байгууллагууд хөрөнгө оруулалтын ажилд тухай бүрт нь газар дээр нь хяналт тавьж ажиллаж байгаа боловч хяналтаар гарсан үр дүнг тайлагнаж ажиллахгүй байна.*

Баянхонгор аймгийн ГХБХБГ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 24 ажилд 25,1 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж үүнээс Боловсролын салбарт 14 ажилд 11,7 тэр бум төгрөг, Эрүүл мэндийн салбарын 2 ажилд 3,3 тэр бум төгрөг, шугам сүлжээний 5 ажилд 5,6 тэр бум төгрөг, олон нийтийн үйлчилгээний бусад 6 ажилд 4,2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдэж манай байгууллагын зүгээс БХТөв, МХГазар, ХОХБТХэлтэстэй хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажиллажээ.

Дээрх хяналт тавьсан хөрөнгө оруулалтад эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ багтсан байна.

Тайлант хугацаанд хяналт хийж илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тухай бүрт нь тусгаж зөрчлийг арилгадаг гэх боловч барилга тус бүрийн зөрчлийг нэгтгэсэн судалгаа байхгүй, хэрхэн зөрчил арилсан талаар үр дүнг тооцохгүй байгаа нь хяналтын ажлын үр дүнг үнэлэх боломжгүй байна. Иймд цаашид хяналтаар илэрсэн зөрчлийг бүртгэлийг бүртгэж, түүнийг шийдвэрлэсэн талаар үр дүнг гаргаж ажиллахыг хяналт хэрэгжүүлдэг байгууллагуудад зөвлөмжөөр хүргүүлэв.

*Б.2.3. Тендер зарлаж гэрээ байгуулсан зарим төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилснөөр санхүүжилтийн зөрүү гарсан байна.*

Шинэжинст сумын цэцэрлэгийн гадна талбайн тохижилтод алаг хавтан зам хийхээр төсөвлөгдсөн байхад түүнийг хийлгүйгээр бетон зам хийсэн, Шинэжинст сумын сургуулийн дотуур байрны дотор сангийн ажил хийхээр гэрээ хийгдэж төсөвлөгдсөн байхад бодит гүйцэтгэлээр цахилгааны монтаж сольж хийсэн ба дээрх ажлаас төсвийн зөрүү гарч байгаа тул зөрүү тооцоог гаргаж ирүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.3 Захиалагч гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?**

Захиалагч санхүүжилтийн гүйцэтгэлийн Барилгын хөгжлийн төвийн хянаанаар ажлыг нэг бүрчлэн тулгаагүйгээс 668.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид илүү олгосон байна.

*Б.3.1 Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих хяналт үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулсан байна.*

Хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэгчээс гарсан ажлын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон аймгийн ГХБХБГ-ын дарга барилга хариуцсан хяналтын инженер тухай бүрт нь гарын үсэг зурж баталгаажуулж байна.

*Б.3.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд тулгуурлан өгөөгүйгээс 668.1 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.*

Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

Эрх шилжиж ирсэн дараах төсөл, арга хэмжээний 2018 оны санхүүжилт аймгийн төрийн санд 6857,1 сая төгрөг ирж, 6828,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, Баян-Ойт сургуульд 6,3 сая, Баянхонгор-Чандмань цэцэрлэгт 12,9 сая, Жинст сумын Соёлын төвд 9,0 сая төгрөг, нийт 28,2 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй буцаан татагдсан байна.

Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	эрх шилжиж ирсэн санхүүжилт	Олгосон санхүүжилт	үнээс	
				Гүйцэтгэгчид олгосон санхүүжилт	зураг төсөв, ТХЗ бусад тооцоо
Баянхонгор сумын ЗДТГ автомашин	Индранил Очир ХХК	35,000.0	35,000.0	35,000.0	-
Баянговь сумын ЗДТГ автомашин	Индранил Очир ХХК	35,000.0	35,000.0	35,000.0	-
Жинст сумын ЗДТГ автомашин	Никёо карс ХХК	35,000.0	35,000.0	35,000.0	-
Өлзийт сумын "Нутгийн удирдлагын ордон	Гал хонгор ХХК	459,999.9	459,999.9	420,827.9	39,172.0
Эрдэнэцогт сумын "Нутгийн удирдлагын ордон	Зүүн шанд ХХК	450,000.0	450,000.0	410,741.4	39,258.6
Баянговь сумын Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Арвин хонгор ХХК	500,000.0	499,982.0	475,538.2	24,443.8
Баян-Ойт цэцэрлэгийн барилга	Хаш гоёо ХХК	499,279.8	493,021.2	453,391.4	39,629.8
Баян-Өндөр сумын сургуулийн засвар	Базардарь ХХК	78,355.7	78,355.7	72,992.3	5,363.4
Баянхонгор сумын 280 ортой цэцэрлэг	Гал хонгор ХХК	1,550,000.0	1,550,000.0	1,505,480.1	44,519.9
Баянхонгор-Чандмань цэцэрлэг	Хаш гоёо ХХК	757,709.8	744,830.7	725,512.0	19,318.7
Богд сумын Соёлын төв	РМВ ХХК	800,000.0	800,000.0	765,385.0	34,615.0
Богд сумын сургуулийн засвар	Төмөрт хос ХХК	57,305.5	57,323.5	53,152.0	4,171.5
Галуут сумын Цэцэрлэг	Базардарь ХХК	48,069.3	48,069.3	44,700.2	3,369.1
Жинст Дотуур байр	Жамъяан пайтан ХХК	745,867.8	745,867.8	671,267.8	74,600.0
Жинст Соёлын төв	Рино инженеринг ХХК	357,625.8	348,606.6	339,654.8	8,951.8
Шинэжинст Дотуур байр	Шинэ Өлгийн зам ХХК	269,477.7	269,477.7	250,862.6	18,615.1
Шинэжинст Цэцэрлэг	Шинэ Өлгийн зам ХХК	60,000.0	60,000.0	55,649.4	4,350.6
Жаргалант СДЭ засвар	Элбата ХХК	55,700.0	55,700.0	51,828.4	3,871.6
Чандмань-Баянхонгор ЭМСалбар засвар /Зооноз/	Чандмань-Баянхонгор ХХК	39,989.7	39,989.7	39,289.2	700.5
ГХБХБГазарын барилгын засвар	Унагатрейд ХХК	22,736.0	22,736.0	7,237.2	15,498.8
	Нийт дүн	6,857,117.0	6,828,960.1	6,448,509.9	380,450.2

Аудитаар газар дээр нь очиж шалгахад зарим төсөл арга хэмжээг бодит гүйцэтгэлээс илүү санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

➤ Баянговь сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн гүйцэтгэлийг 2018.11.19 –нд гаргахдаа Хана хамар ханын ажлыг 100 хувь буюу 193,4 сая, гүйцэтгэсэн гэж гаргасан байхад тухайн ажил нь хийгдээгүй.

➤ Жинст сумын 150 хүүхдийн дотуур байрны гүйцэтгэлийг 2018.12.15-нд гүйцэтгэл гаргахдаа хана, хамар ханын ажил 131,4 сая буюу 100 хувь, шалны ажил 5.3 сая буюу 5 хувь, хаалга цонхны ажил 25.9 сая, дээврийн ажил 35,9 сая буюу 100 хувь нийт 295.9 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн гэж санхүүжилт гаргасан боловч ажил хийгдээгүй

➤ Жинст сумын 240 суудалтай соёлын төвийн барилгын ажил нь гаргасан гүйцэтгэлээр газрын ажил, суурийн ажил, хана, хамар ханын ажил, баганан суурийн ажил түшиц ханын ажлыг 464.3 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасныг 357.6 сая төгрөгөөр хянасан байхад газар шорооны ажил хийгдсэн, суурийн ажил эхэлсэн байдалтай байна. Дээрх ажлын гүйцэтгэл нь бодит байдлаар гаргасан гүйцэтгэлийн 50 хувь хийгдсэн байна.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБХОТХ-ийн мэргэжилтнээс тодруулахад Боловсролын болон Эрүүл мэндийн яам нь хөрөнгө оруулалтын ажлын хяналтыг Барилгын хөгжлийн төвөөр хийлгэхээр гэрээ байгуулсан бөгөөд хяналтын зардлыг тус газарт шилжүүлж байгаа. Бид газар дээр нь очиж хяналт хэрэгжүүлэхгүй байгаа гэсэн тайлбар өгөв.

Барилга хөгжлийн төвөөс хяналт тавьж илүү олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд гарын үсэг зурж баталгаажуулсан холбогдох албан тушаалтнуудад хариуцлагын арга хэмжээ авах асуудлыг Үндэсний аудитын газарт уламжилж байна.

Дээрх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд нийт 668,1 сая төгрөг илүү олгосон байгаа тул илүү авсан санхүүжилтийн ажлыг бүрэн гүйцэтгүүлэх албан шаардлагыг гүйцэтгэгч компаниудад хүргүүлэв.

*Б.3.3 Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг журамд заасны дагуу сар бүр Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.*

2018 онд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц үр дүнгийн талаар Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан

“Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналын журам”-ын 6 дугаар хавсралтаар гарган журамд заасан хугацаанд хүргүүлж ажилласан байна.

*Б.3.4 Гүйцэтгэгчидтэй хийсэн гэрээний хугацааг хуульд заасан санхүүжүүлэх эх үүсвэртэй уялдуулж хийгээгүйгээс үүргийн хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.*

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын 23 төсөл арга хэмжээнээс 13 ажлыг ашиглалтад хүлээж авсан бөгөөд үүний 6 ажлыг хугацаанд нь хүлээн авч, 7 ажлыг 5-47 хоногоор хугацаа хэтрүүлэн ажлыг гүйцэтгэсэн байна. Хугацаа хэтэрсэн ажлыг гүйцэтгэгч тус бүрээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний хугацаа		Хүлээлгэн өгсөн огноо	Хэтэрсэн хоног
			Эхлэх	Дуусах		
1	Засаг даргын Тамгын газрын барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	Зүүн шанд ХХК	2018.07.25	2018.12.25	2018.12.30	5
2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын засвар Баянхонгор	Унага трейд ХХК	2018.07.25	2018.09.05	2018.10.17	42
3	Сургуулийн дотуур байрны халаалт, цахилгааны засвар /Баянхонгор, Шинэжинст сум/	Шинэ өлгийн зам ХХК	2018.07.25	2018.08.31	2018.09.29	28
4	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Жаргалант сум/	Елбата ХХК	2018.06.11	2018.07.30	2018.08.28	27
5	Сургуулийн дотуур байрны халаалт, цахилгааны засвар /Баянхонгор, Шинэжинст сум/	Шинэ өлгийн зам ХХК	2018.07.25	2018.08.31	2018.09.29	28
6	Сургуулийн гадна шугам сүлжээний засвар /Баянхонгор, Баянөндөр сум/	Базар дарь ХХК	2018.09.03	2018.10.10	2018.10.22	12
7	ЗООНОЗ-ын барилгын сантехникийн их засвар	Баянхонгор-Чандмань ХХК	2018.08.24	2018.09.25	2018.11.12	47

Тайлант онд гүйцэтгэж дуусах боломжгүй, он дамжин хэрэгжиж буй барилгын ажлын гэрээг хийхдээ санхүүжүүлэх эх үүсвэрийг харгалзахгүйгээр тухайн онд ашиглалтад оруулахаар зааж гэрээ хийж байгаа нь гэрээний хугацаа зөрчигдөх шалтгаан болж байгаа тул цаашид тайлант онд санхүүжүүлэх дүн, ажлын графикийг харгалзан үзэж тухайн онд хийгдэх ажлын нэр, мөнгөн дүнг тусгаж гэрээг хийж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.4 Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?**

*Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.*

*Б.4.1 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж байна.*

Эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтсээс хяналт тавьж санхүүжилтийн мэдэгдлийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсний үндсэн дээр зарлагын гүйлгээг хийж байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн мэргэжилтнээс хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тодруулахад тодруулахад бид ажлын гүйцэтгэлд бол хяналт тавихгүй харин санхүүжилтийн мэдэгдэлд дагалдаж ирж байгаа ажлын гүйцэтгэлийн баталгаажилт, гарын үсгийн бүрдэл, НББ-ийн анхан шатны баримт нэхэмжлэх зэргийн дүнг тулган гүйлгээ хийж байна гэсэн тайлбар өгөв. Харин Сангийн сайдын 2016 оны 415-р тушаалаар батлагдсан журмын 4-р хавсралтаар гаргаж буй барилгын ажлын гүйцэтгэлд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн дарга гарын үсэг зурж байна.

*Б.4.2 Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.*

Хөрөнгө оруулалтын ажилд гүйцэтгэгчээс гарсан ажлын гүйцэтгэлийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон аймгийн ГХБХБГ-ын дарга барилга хариуцсан хяналтын инженер тухай бүрт нь гарын үсэг зурж баталгаажуулж байна.

Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг үе шат бүрээр нь хянасны үр дүнд 2018 онд эрх шилжиж ирсэн барилгын болон засварын ажлыг чанартай үр дүнтэй гүйцэтгүүлсэн бөгөөд үүний үр дүнд ашиглалтад орсон 12 объект нь чанарын шаардлага хангасан, зөрчил доголдолтой асуудал гараагүй байна. Үүний 3 нь шинээр баригдсан барилга, 9 нь засварын ажил байна.

Мөн барилгын ажлын гүйцэтгэлд Барилгын хөгжлийн төвөөс ажлын үе шат бүрт ирж хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

**В.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухай жилд хүрэх зорилтот түвшинг хангасан уу?**

*Баянхонгор аймагт 2018 онд эрх шилжин хэрэгжиж ашиглалтад орсон төсөл арга хэмжээ бүрэн хүчин чадлаараа хэвийн ашиглагдаж байгаа хэдий ч дэвшүүлсэн зорилт хүрэх түвшинг тооцох баримт материал байхгүй байна.*

*В.1.1 2018 онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээ бүрэн хүчин чадлаараа хэвийн ашиглагдаж бай боловч Баян-Ойт сургуулийн барилгыг улсын комиссоор хүлээж аваагүй байхад сургалтын үйл ажиллагаа явагдаж байгаа нь Барилгын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна.*

Баянхонгор аймагт эрх шилжиж ирсэн 23 төсөл арга хэмжээнээс 12 ажил, 3 автомашиныг ашиглалтад хүлээн авсан байна. Шинээр орсон Эрдэнэцогт, Өлзийт сумдын ЗДТГ-ын барилга, 9 засварын ажил, 3 автомашин нь ашиглалт хэвийн, бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. Аудитаар тус хөрөнгө оруулалтын ажлуудын чанар байдлын тодорхойлолтыг ашиглагч байгууллагуудаас гаргуулан авав.

Харин Баян-Ойт сургуулийн барилгын спорт заал, гадна тохижилтын ажил нь 2019 онд гүйцэтгэхтэй холбоотойгоор тус барилгыг улсын комиссоор хүлээж аваагүй байхад сургалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн байгаа Барилгын тухай хуулийн 37.6-д заасан “Дуусаагүй, дууссан боловч ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно” заалтыг зөрчсөн тул тухайн асуудлын зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэв.

**В.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож байна уу?**

*Баянхонгор аймагт 2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр ашиг, бодит үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.*

*В.2.1. Баянхонгор аймагт 2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр ашиг, бодит үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.*

Баянхонгор аймагт 2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс эрх шилжээгүй хөрөнгө оруулалтын 2 төсөл арга хэмжээ, эрх шилжсэн төсөл арга хэмжээнээс 13 төсөл арга хэмжээг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Дээрх хөрөнгө оруулалтаас Баян-Ойт цогцолбор сургууль ашиглалтад орсноор тус сургуулийн хичээллэх орчин сайжирж, нэг ширээнд 3 хүүхэд сууж хичээллэдэг

байдал арилж хүүхдийн сурах нөхцөл хангагдсан бодит үр нөлөө гарсан, бусад сургуулийн нэг ээлжинд хичээллэдэг байдал зогссон зэрэг бодит үр нөлөө гарсан байхад аймгийн хөрөнгө оруулалтуудын үр ашигийн тооцоо хийж бодит үр нөлөөг тооцоогүй байна.

Иймд цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын үр ашиг, үр нөлөөг тооцож, ажиллахыг аймгийн ТЕЗ-д зөвлөмжөөр хүргүүлэв.

*В.2.2 ЗГХЭГ-аас эрх шилжиж ирсэн Баянговь, Жинст сумдын авто машины 35.0 сая төгрөгийн төсвийг орон нутгаас хөрөнгө нэмэгдүүлж шатахуун зарцуулалт ихтэй, хуучин машин авч үргүй зардал гаргасан байна.*

Баянхонгор аймагт эрх Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 35.0 сая төгрөгөөр 3 автомашиныг худалдан авах эрх шилжиж ирсэн байна.

Аудитаар Жинст сумын ЗДТГ-ын авто машин нь тухайн байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байсныг Жинст сумын Засаг даргаас албан бичгээр тайлбар авахад “Никкёо карс”ХХК-аас Лексус-470 маркын автомашиныг 41.8 сая төгрөгөөр тохирч 35.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба үлдэгдэл 6.8 сая төгрөгийн шилжүүлсэн тохиолдолд эзэмшигчийг шилжүүлнэ гэсэн тайлбар өгөв. Тухайн автомашины гэрээ, хүлээлцсэн акт, нэхэмжлэх зэрэг нь 35.0 сая төгрөгөөр хийгдсэн тул автомашиныг ашиглагч байгууллагын нэр дээр шилжүүлж авах албан шаардлагыг хүргүүлж, цаашид дахин нэмэгдэл зардал орон нутгийн төсвөөс гаргахгүй байж Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийн аймгийн Засаг даргад хүргүүлэв.

*В.2.3 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.*

Өмнөх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудит нь судалгааны түвшинд хийгдсэн бөгөөд орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн зөвлөмжид 3 заалт бүхий зөвлөмжийг оруулсан байна. Үүнд

1.Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд тооцох хариуцлагыг тодорхой зааж, үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

